**МОНГОЛ УЛСЫН**
**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrtd.gov.mn, http://www.mrtd.gov.mn

2022.10.04 № 03/4544

танай ____________-ны № ____________-т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН ГАЗАРТ

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан "Хөвсгөл зам" ХХК-д гэрээний дагуу олгох 136,137,808.50 (нэг зуун гучин зургаан сая нэг зуун гучин долоон мянга найман зуун найман төгрөг тавин мөнгө) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт: 13 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД

9020050420 5919487 СБА7509

080003303

**Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах данснаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт**

*2022.10.04*

*/төгрөгөөр/*

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Гүйцэтгэгч компани | 2022 оны эхний үлдэгдэл | 2022 онд нэмэгдсэн орлого | 2022 онд олгосон дүн | Одоо олгох дүн | Үлдэгдэл | Гэрээний заалт | Шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Эрх нээлгэх нийт дүн** | | **136,137,808.50** | **0.00** | **0.00** | **136,137,808.50** | **0.00** | | |
| 1 | Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай авто зам, 27 км /Завхан, Их-Уул сум, Хөвсгөл, Жаргалант сум/ | "Хөвсгөл зам" ХХК | 136,137,808.50 | | | 136,137,808.50 | 0.00 | Тусгай нөхцлийн 32.1: Чанарын баталгааны хугацаа: Ажлыг ашиглалтад хүлээн авсан өдрөөс хойш авто замын барилга байгууламжийн зүгшрүүлэх тохируулах хугацаа 1 жил байна. | Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад авах ажлын хэсгийн 2021.07.09-ний өдрийн 11 дугаартай акт, дүгнэлт, "Хөвсгөл АЗЗА" ТӨХК-ийн 2022.09.19-ний өдрийн 98 тоот албан бичиг |

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга Ч.Ренчиндамба

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч Н.Баярсайхан

"Авто зам, замын байгууламжийн барилгын ажилэхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын гуравдугаар хавсралт

# АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН АКТ, ДҮГНЭЛТ

Мөрөн хот

2021 оны 07 сарын 09-ний өдөр Дугаар:11

## НЭГ. Ерөнхий мэдээлэл

1.1.Авто зам, замын байгууламж, объектын нэр: Хөвсгөл аймгийн Жаргалант суманд Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Жаргалант сум хүртлэх хайрган хучилттай 27 км авто замын ажил

Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц. Хайрган хучилттай авто зам

Зургийн шифр16/18 Магадлалын дугаар: 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 84/2019

Хаяг: Зам тээвэр хөгжлийн яамны Зам тээвэр хөгжлийн төв

1.2.Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг:Хөвсгөл зам ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 1711006038, 2034719

1.3.Туслан гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг:Байхгүй

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.4.Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр: Ар Си Эс Си ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 5464013

1.5.Захиалагч байгууллагын нэр, хаяг: Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгийн газар

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 9070354

1.6.Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллагын нэр, хаяг:

Ихэр Мөнх ХХК Улаанбаатар хот Баянгол дүүрэг 10-р хороо Хасбаатарын гудамж 3Н02-07

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .5914337..

1.7. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 06 өдрийн А/346 шийдвэрээр зохион байгуулсан 16 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай Хөвсгөл зам ХХК-ын 2021 оны 06 сарын 30 -ны өдрийн 21.01/148 дугаар мэдэгдлийн дагуу 2021 оны 07 сарын

1.Авто замын тухай хуулийн 27.3-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн паспорт, картыг хянаж, хүлээн авч, бүртгэл мэдээллийн санд баяжилт хийж, холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх,

2.Авто замын тухай хуулийн 23.3.-т заасны дагуу чанарын баталгаат хугацаа дууссанаас хойш авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засварын ажлыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

3.Ажлын хэсгийн акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 2 хуудас материал, барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалтыг хавсаргав.

## ГУРАВ. Актын баталгаажуулалт

Хөвсгөл аймгийн Жаргалант суманд Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Жаргалант сум хүртлэх хайрган хучилттай 27 км авто замын ажлыг ашиглалтад авах дүгнэлт гаргасан.

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ажлын хэсгийн дарга:

Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга — Б.Энхжаргал

Нарийн бичгийн дарга:

Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Мэргэжилтэн — Д.Нямбат

Гишүүд:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Авто замын хяналтын улсын байцаагч — Ц.Дэлбадрах

Хөвсгөл аймгийн Ерөнхий Архитектор — Бадамсэрээжид

Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа — Д.Ууганбаяр

Хөвсгөл аймгийн Архивын тасгийн дарга — Ж.Жавзанпагма

Хөвсгөл аймгийн Барилга захиалагчийн хяналтын төвийн дарга — О.Төмөрхуяг

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн — Ц.Бэхбаяр

Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах Улсын хяналтын ахлах байцаагч, хошууч — Л.Бямбасүрэн

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ:**

*ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА*

___________ *Л.ГАНБОЛД*

(Гарын үсэг)

**ГҮЙЦЭТГЭГЧ:**

*"ХӨВСГӨЛ ЗАМ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ*

___________ *Г.ЛХАГВАСҮРЭН*

(Гарын үсэг)

***АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОСОО ТЭНХЛЭГИЙН ЗАМ, ЦЭЦЭРЛЭГ-ТОСОНЦЭНГЭЛ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМ ХҮРТЭЛХ ХАЙРГАН ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 27 КМ /ЗАВХАН, ИХ-УУЛ СУМ, ХӨВСГӨЛ, ЖАРГАЛАНТ СУМ/ ЗАМ БАРИХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ***

Дугаар № *ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01-гэрээний сунгалт*

Хөвсгөл аймаг

## НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас ***Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас ***Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 13 дугаар багт байрлах "Хөвсгөл зам" ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Лхагвасүрэн*** (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 12 сарын 02-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, Автозамын тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах гэрээ нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох бөгөөд өмнөх *ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01* дугаартай гэрээний салшгүй хэсэг болно.
2. Захиалагч нь нь ***Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай авто зам, 27 км /Завхан, Их-Уул сум, Хөвсгөл, Жаргалант сум/ зам барих ажил, ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01***-г (цаашид "ажил" гэх) ***5,159,549,552 (Таван тэрбум нэг зуун тавин есөн сая таван зуун дөчин есөн мянга таван зуун тавин хоёр) төгрөгөөр*** (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендер, Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын гэрээ сунгах тухай 2020 оны 4/724 дугаар хүсэлт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 27 өдрийн А/601 дүгээр захирамжийг үндэслэн ***ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01*** дугаартай гэрээг сунгав. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: **5,159,549,552 (Таван тэрбум нэг зуун тавин есөн сая таван зуун дөчин есөн мянга таван зуун тавин хоёр)** төгрөг.

   Хөрөнгийн эх үүсвэр: Улсын төсвийн хөрөнгө оруулалт
   2019 онд: 1,000,000,000 төгрөг;
   2020 онд: 4,159,549,552

4. Гүйцэтгэгч нь **Жаргалант сумын 4 дүгээр багт** байршилтай **27 км хайрган хучилттай автозам барих, гүүр, хоолой байгуулах ажлыг** 2019 оны 7 дугаар сарын 15-ны өдөр эхэлж, 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад оруулна." гэснийг 2019 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтанд оруулна гэж өөрчлөв. Гэрээнд сунгалт хийгдсэнээр гэрээний нийт үнэ болон ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орохгүй болно.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний бичиг баримт" гэх). Үүнд:
   5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   5.2. Тендер;
   5.3. Гэрээний тусгай нөхцөл;
   5.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   5.5. Техникийн тодорхойлолт;
   5.6. Зураг;
   5.7. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь:

5.8. Санхүүжилтийн хуваарь;
5.9. Гүйцэтгэлийн баталгаа:
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь. Өмнөх *ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01* дугаартай гэрээний тавдугаар бүлэгт заасан ажлын үе шатны хуваарийн хугацааг өөрчилж энэхүү гэрээнд хавсаргав.
5.11. Бусад шаардлагатай баримт бичиг;

6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
7. Талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ харилцан хүндэтгэлтэйгээр асуудалд хандаж, хэн нэг нь давуу эрх эдлэхгүйгээр хамтын шийдвэр гаргаж ажиллана.
8. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ. Өмнөх *ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01* дугаартай гэрээний гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тусгай нөхцлийн хавсралтанд заасан нөхцөл зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
9. Өмнөх гэрээний тусгай нөхцлийн ГЕН-46.1 дэх заалтыг гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний төлбөрийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй гэж өөрчлөв.
10. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
11. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
12. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.
13. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл бий болсоноос бусад тохиолдолд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг сунгаж өөрчлөхийг хориглоно.

14. Захиалагч, гүйцэтгэгч нь өмнөх гэрээний гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл түүний хавсралтад заасан эрх, үүргийг заавал хэрэгжүүлж, хариуцлагыг хүлээнэ.

**Баталгаажуулалт:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

_____________Э.АЗЗАЯА

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 99069044

**ХЯНАСАН:**

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА

_____________Б.БОЛД

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
Аймгийн ЗДТГ-ын “А”байр
Утасны дугаар: 99034867

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

_____________Г.ГАНДЭЛГЭР

Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
ЗДТГ-ын “А” байр
Утасны дугаар: 88115447

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“ХӨВСГӨЛ ЗАМ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ НЯБО

_____________Н.НЯМБАЯР

Хөвсгөл аймаг,Мөрөн сум,13-р баг,
Утас: 98030325
Харилцагч банкны нэр:ХААН банк
Дансны дугаар: 5890038249
Регистрийн дугаар: 2034719

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

Л.ГАНБОЛД

(Гарын үсэг)

ГҮЙЦЭТГЭГЧ:

"ХӨВСГӨЛ ЗАМ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЛХАГВАСҮРЭН

(Гарын үсэг)

## *АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОСОО ТЭНХЛЭГИЙН ЗАМ, ЦЭЦЭРЛЭГ-ТОСОНЦЭНГЭЛ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМ ХҮРТЭЛХ ХАЙРГАН ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 27 КМ /ЗАВХАН, ИХ-УУЛ СУМ, ХӨВСГӨЛ, ЖАРГАЛАНТ СУМ/ ЗАМ БАРИХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ*

Дугаар № *ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01*

Хөвсгөл аймаг

### НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас *Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд* (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "*Хөвсгөл зам" ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Цэрэнсүрэн* (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь *Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай авто зам, 27 км /Завхан, Их-Уул сум, Хөвсгөл, Жаргалант сум/ зам барих ажил, ЗТХЯ/201901024/1.4.3-2-А/01-г* (цаашид "ажил" гэх) ***5,159,549,552 (Таван тэрбум нэг зуун тавин есөн сая таван зуун дөчин есөн мянга таван зуун тавин хоёр)*** төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн 5,159,549,552 (Таван тэрбум нэг зуун тавин есөн сая таван зуун дөчин есөн мянга таван зуун тавин хоёр) төгрөг

   Хөрөнгийн эх үүсвэр: Улсын төсвийн хөрөнгө оруулалт
   2019 онд: 1,000,000,000 төгрөг;
   2020 онд: 4,159,549,552

4. Гүйцэтгэгч нь Жаргалант сумын 4 дүгээр багт байршилтай 27 км хайрган хучилттай автозам барих, гүүр, хоолой байгуулах ажлыг 2019 оны 7 дугаар сарын 15-ны өдөр эхлэж, 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдөр дуусгаж ашиглалтад оруулна.

ГЕН 40.1: Гүйцэтгэгч гэрээний эцсийн гүйцэтгэлийн тооцоог төслийн менежерт ирүүлж, баталгаажсан холбогдох баримт бичгийг захиалагчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор захиалагч гэрээний төлбөрийг төлөх бөгөөд хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хоцруулсан төлбөрт 0.1 хувийн торгуулийн дараагийн төлбөртэй хамт төлөх буюу торгуулийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна

ГЕН 45.1: Захиалагч гүйцэтгэгчид төлөх гүйцэтгэлийн төлбөр бүрээс түүний 7 хувьтай тэнцэх хэмжээг чанарын баталгааны барьцаа хөрөнгө болгон захиалагчийн дансанд суутгаж үлдээнэ. Чанарын баталгаат хугацаа дуусcны дараа тэр хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан төслийн менежрийн мэдэгдлийг үндэслэн төлнө.

ГЕН 46.1. Гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутам гэрээний үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй.

ГЕН 52.1: Гүйцэтгэгч ажлын явцад зам, талбай, гудамж сэтэлж, мод, ногоон байгууламжийг түр хайлсан бол барилга ашиглалтанд хүлээн авахаас өмнө тэдгээрийг сэргээсэн байна. Нөхөн сэргээгээгүй тохиолдолд барилга ашиглалтанд хүлээн авахыг хориглоно.

ГЕН 55.1: Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагчийн шаардсан ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.9-д заасан мэдээллийн самбар зэргийг 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор захиалагчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй тохиолдолд гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрөөс гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх мөнгийг захиалагчийн дансанд суутган үлдээнэ.

## ДОЛОО: ХАРИУЦЛАГА

7.1. Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн талаар бүрдүүлж өгсөн баримт материалын үнэн зөвийг бүрэн хариуцна.

7.2. Талууд бие биенийхээ өмнөөс гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

7.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэхгүй. Шилжүүлсэн тохиолдолд үүсэх үр дагаврыг шилжүүлсэн тал өөрөө хариуцна.

7.4 Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилчдыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл гаргасан өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөрийг эдгээр зардлаас хасна.

7.5. Төсвийн орлогын бүрдэлтээс шалтгаалсан төлбөрийн саатлыг санхүүжүүлэгч хариуцахгүй

7.6 Барилгын тухай хуулийн холбогдох заалт болон энэ гэрээг зөрчсөн тал барилгын тухай хуулийн 50, Иргэний хуулийн 352, 353, 354, 355 дугаар зүйлүүдэд заасан үүрэг хариуцлага хүлээнэ.

7.7. Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ: ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1. Гэрээг 5 хувь үйлдэж захиалагч тал гурав, гүйцэтгэгч тал 2 хувийг хадгална. Талууд гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2 Энэхүү гэрээний нөхцөлд гэрээний үнэ өөрчлөхөөс бусад асуудлаар нэмэлт гэрээ байгуулж болох бөгөөд уг нэмэлт гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.